

“СҮРЬЕЭ БОЛОН ЯМ ӨВЧНИЙ ХЯНАЛТ” САТРЕПС ХАМТАРСАН ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 4 ДЭХ УДААГИЙН ХУРЛЫН НЭЭЛТИЙН ҮГ

2025.02.05

Монгол-Япон Улсын Засгийн газар хоорондын хамтарсан төсөл

Япон Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд 2020 оны 1 сарын 16-ны өдөр солилцсон Техникийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд “Сүрьеэ болон ям өвчний хяналт” төсөл хэрэгжиж байна. Хоёр тал төслийн хэрэгжилтийг ЖАЙКА-тай хамтран хариуцаж, бусад холбогдох байгууллагуудтай уялдуулан, төслийн бие даасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх явц болон хэрэгжилтийн дараах тогтвортой байдлын чиглэлээр Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах хувь нэмрээр хоёр тал тохиролцон, гэрээг үзэглэсэн.

Сүрьеэ, ям өвчнийг нэг эрүүл мэнд үзэл баримтлалд тулгуурлан, шинжлэх ухааны үндэслэлтэй хянах тогтолцоог Монгол Улсад бүрдүүлэх зорилго бүхий энэхүү төслийг Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Мал эмнэлгийн хүрээлэн, Япон улсын Хоккайдогийн их сургууль, Япон улсын сүрьеэ судлалын хүрээлэн хамтран хэрэгжүүлж байна. Монгол улсын БСШУЯ, Сангийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газар, Зоонозын өвчин судлалын үндэсний төв уг төслийг дэмжин, хамтран ажиллаж ирсэн.

Японы олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллага, Эрүүл мэндийн судалгаа, хөгжлийн байгууллагын хамтарсан "Тогтвортой хөгжлийн төлөө шинжлэх ухаан, технологийн судалгааны түншлэл" (САТРЕПС)-ийн санхүүгийн дэмжлэг, техникийн туслалцаатайгаар “Сүрьеэ болон ям өвчний хяналт” төслийг 2020-2025 онуудад амжилттай хэрэгжүүлж байна.

Өнөөдрийн хамтарсан зохицуулах хорооны 4 дэх удаагийн хуралдаанд 2 орны дээрх байгууллагын зочид төлөөлөгчид хүрэлцэн ирсэнд төслийн багийн өмнөөс гүнээ талархал илрхийлье.

Өнгөрсөн хугацаанд төслийн хүрээнд төлөвлөгдсөн ажлуудыг хэрэгжүүлж, тулгамдсан саад тотгорыг тухай бүрт шийдвэрлэснээр олон бодит үр дүн, ололт амжилт гаргасан ба төслийн хамтарсан зохицуулах хорооны хурлыг 3 удаа, төслийн хүрээнд хийгдсэн эрдэм шинжилгээ судалгааны ажлуудыг хэлэлцэх Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2 удаа амжилттай зохион байгуулж ийнхүү төслийн шийдвэрлэх хариуцлагатай мөч буюу төгсгөлийн жилд ирлээ.

Уг төслийг анх төлөвлөхдөө бид дараах 4 үр дүнг гаргахаар ажилласан билээ:

1. Халдварт зооноз өвчнийг оношлох шинэ техник, технологид суурилсан түргэвчилсэн оношлуурыг Япон эрдэмтэд зохион бүтээж үхрийн сүрьеэ болон

адууны ямын халдварыг илрүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх замаар Монгол Улсад одоогийн хэрэглэгдэж байгаа сүрьеэ, ям өвчнийг оношлох аргыг шинэчилж зоонозын өвчний оношилгоог сайжруулна..

2. Адууны ям, үхрийн сүрьеэ зэрэг зоонозын халдварын эрсдэлийн үнэлгээ хийж, бодит нөхцөл байдлыг тодорхойлно.
3. Адууны ям, үхрийн сүрьеэ зэрэг зооноз өвчний тархалт, халдварлалтын бодит нөхцөл байдлыг ийлдэс судлал,молекул биологийн аргаар тогтооно.
4. Нэг эрүүл мэнд (One health) үзэл баримтлалд тулгуурласан зооноз халдварт өвчнийг хянах платформыг бий болгоно.

Өнөөдрийн хамтарсан зохицуулах хорооны 4 дэх удаагийн хурлаар 2024 онд төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүнгийн талаар илтгэхээс гадна бид дээрх хүлээгдэж буй үр дүнгийн хамгийн чухал үр дүн буюу цаашид энэхүү төслийн тогтвортой байдлыг хангах хамтарсан тандалтын тогтолцоог хэрхэн бий болгох асуудлыг ярилцаж, хэлэлцэж, шийдвэр гаргахыг зорилго болгож байна. Та бүхэн өөрсдийн мэргэн оюун, туршлага, мэдлэгээ хуваалцан дээрх шийдэлд хүрнэ хэмээн гүнээ итгэж байна.

Ингээд хурлыг нээснийг мэдэгдэж, хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье!